



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/252

Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XIII/90 дүгээр тогтоолын 05 дугаар хавсралтын 1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган сумын хэмжээнд орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийг арчлах, урсгал засварын ажилд 20,000,000 (хорин сая) төгрөгөөр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах эрхийг Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал)-д олгосугай.

2.Гэрээнд заагдсан ажлуудыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгүүлж, хүлээн авахыг Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал)-д үүрэг болгосугай.

3.Засварын ажлын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Зам тээвэр, эрчим хүч, ус сувгийн бодлого хариуцсан мэргэжилтэн (Ш.Цэнд), Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал), чанарын болон хугацааны хувьд хөндлөнгийн хяналт тавихыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Салбарын хяналт зохицуулалтын хэлтсийн Авто замын хяналтын Улсын байцаагч (С.Сүхбаатар) нарт тус тус даалгасугай.

4.Дээрх ажлын санхүүжилтийг Аймгийн авто замын сангийн батлагдсан төсвөөс гэрээнд заагдсан үнийн дүнгээр тухай бүр санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Сайнзаяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ГҮРЭВ-ОЧИР



6326010354